

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 04 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар: 2016/02

Улаанбаатар хот

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр МҮЭ-ийн “Соёлын Төв Ордон”-д өглөөний 10:00 цагт МҮЭ-ийн “Соёлын Төв Ордон”-ны хурлын бага танхимд эхэллээ.

Хуралд Хувьцаа эзэмшигчдээс гадна ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа, Б.Наранбаатар, Б.Батзаяа, Ж.Оюунгэрэл, Ч.Ганхуяг болон ТУЗ-ийн Хараат бус гишүүн Л.Чинбат, Б.Амарсанаа, Л.Ундаргаа нар буюу ТУЗ-ийн бүх гишүүд, “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал болон удирдах албан тушаалтнууд оролцлоо.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ-ийн 2016 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 2016/06 тоот тогтоолоор томилогдсон ТУЗ-ийн гишүүн Ч.Ганхуяг даргалав.

Хурлын ирц: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ҮЦТТТХТ-өөс 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр тасалбар болгон ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаанд хамрагдсан нийт 88,262,185 хувьцаа эзэмшдэг 11 хувьцаа эзэмшигч биеэр оролцож нийт хувьцаа эзэмшигчдийн 88.6 хувийг бүрдүүлсэн тул энэ тухай хурлын дарга болон хувьцаа эзэмшигчдэд Тооллогын комиссоос мэдэгдэж, Хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал хүсэлт байхгүй гэснээр хурлыг эхлүүлэхээр шийдвэрлэлээ.

Хурлын дарга Ганхуяг: Хурлын хэлэлцэх асуудалд орсон тайлан, мэдээлэл танилцуулах тул ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, гишүүн Б.Батзаяа, Д.Далгэрмаа, Гүйцэтгэх захирал Б.Батсайхан нарыг индэрт гарч суудлаа эзлэхийг урилаа.

Хурлын дарга Ч.Ганхуяг: ТУЗ-ийн зүгээс хурлын даргаар томилж, хэлэлцэх асуудлынх нь дагуу хурлыг удирдан явуулах үүргийг гишүүн миний бие Чулууны Ганхуягт ноогдуулсан байгаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлахдаа ТУЗ нь хуулийнхаа дагуу “Бүртгэлийн өдөр” гэж тогтоодог. Тэр өдрийн арилжааны хаалтын үеэр хувьцаа эзэмшигчид бүртгэгдсэн байгаа хувь нийлүүлэгчид саналын эрхтэйгээр өнөөдрийн хуралд орно гэсэн байдаг. Үүний дагуу өнөөдрийн бүртгэлийн асуудал буюу надад танилцуулснаар 88.6 хувиар хурлын ирц бүрдэж байна. Санал, асуух зүйл байна уу?

/Хувьцаа эзэмшигч Х.Батхишиг 13.2 хувийн саналын эрхтэйгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөө ирүүлсэн боловч бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон жагсаалтаар 5.2 хувийн буюу 5,204,852 ширхэг хувьцааны саналын эрхтэйгээр энэхүү хуралдаанд оролцохоор болов./

Хувьцаа эзэмшигч Х.Батхишигийг төлөөлж ирсэн Тулгат: Манайх 5.2 хувьтай байгаад нэмж хувьцаа авсанаар 13 хувьтай болсон байгаа. 3 сарын 18-наар

тасалбар болгосон гэдгийг мэдэж байна. Миний хувь 13 хувийг төлөөлж байгаа гэдгээр энэ хуралд оролцож байна гэж ойлгож байна. Тайлбар хийж өгнө үү.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Бид нар энд тодорхой хэмжээнд түүхэн үйл явцад оролцоод байгаа. 3 дугаар сарын 18-наас өмнө энэ арилжаа явагдсаныг би мэдэж байна. Блок арилжаагаар 2 хувь, Хөрөнгийн биржийн арилжаагаар “Хишиг арвин” компани нь мөнгөө гаргаад худалдагч тал болох Капитрон банк болон нөгөө талд Түвшин гэдэг хувь хүмүүсээс хувьцаа авч бүртгэлээ хийсэн байгаа. Бид энэ хүмүүсийн хувьцаагаа аваад эрхийг нь хэрэгжүүлэх асуудлыг хүндэтгэн үзэх ёстой байх. Хурлын явцад 96, 97 хувь орчим оролцож байгаа. Иймээс ҮЦТТТХТ-өөс лавлагаа гаргуулж аваад энэ хуралдаа итгэмжлэлтэй ирсэн шинэ хувьцаа эзэмшигчээ өнөөдрийн хуралд саналын эрхтэйгээр оролцуулья гэсэн саналтай байна. Эсэргүүцэж байгаа, өөр саналтай, асуулттай хүн байна уу. Протокол хөтөлж байгаа учраас хувьцаа эзэмшигчид маань нэрээ хэлээд асуудлаа тавиад явчихаарай.

Хувьцаа эзэмшигч Ганболд: Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг ҮЦТТТХТ-өөс 18-ны өдөр авна гэж ойлгоод байгаа. Энэ хүн энэ өдрөөс өмнө авсан байгаа бол Батхишиг гэдэг хүний нэр дээр бүх хувьцаанууд нь бүртгэлтэйгээр тархалтын судалгаанд гаргагдсан байх ёстой. Тэрний дагуу багтаж байвал авна. Тэрнээс хойш авсан бол хойш авсан хувьцааныхаа саналын эрхээр хуулиараа оролцох эрхгүй. Иймээс байгаа саналын эрхээрээ энэ хуралд оролцоно. Ирцээ ч гэсэн тэгэж зарлагдах байх гэж хүсэж байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Тэгэхээр манай хүмүүс харьцаж байгаа брокерийн компаниараа дамжуулаад мэдээллээ аваад 3 сарын 18-ны арилжааны хаалтаар өнөөдөр “Хишиг арвин” компанийн төлөөлөл болох Батхишиг гэдэг хүн дээр 2 хувь, нэмэх нь 6 хувь нэмэгдэж бүртгэгдсэн байна уу үгүй юу гэдгийг тодруулаад энд хурлын ирцыг нэгэнт хурлын ирц бүрдчихсэн боловч яг хэдэн хувь байх уу гэдгийг таны хэлж байгаагаар хуулийнх нь шаардлагын дагуу ирцдээ бүртгээд оруулаад явъя. Түрүүчийн манай хүмүүсийн мэдээлснээр 3 сарын 18-ны мэдээг авчихсан байгаа. Энэ мэдээгээр 88,6 хувийн ирцтэйгээр “Монгол шуудан” ХК-ийн ээлжит тайлангийн хурал эхлэх нь. Өөр саналтай хүн байна уу. Байхгүй бол эхлэхийг зөвшөөрөх үү.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр хурлыг цааш үргэлжлүүлэв.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Татгалзсан, түтгэлзсэн хүн байхгүй бол хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцааны 100 хувийн саналаар хурлаа эхэлье. Хурлын тэмдэглэлийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ хариуцан хөтөлж байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Дараагийн асуудал бол бид хурлынхаа даргыг албан ёсоор баталгаажуулах ёстой. ТУЗ-ийн даргын саналаар надад энэ хурлыг удирдах үүрэг өгөөд ТУЗ-ийн гишүүд маань дэмжээд өнөөдрийн хурлыг удирдаж байна. Өөр санал, асуулттай хүн байна уу. Байхгүй бол би хурлаа цааш нь даргалаад явъя гэсэн саналыг оруулж байна. Татгалзсан, түтгэлзсэн хүн байна уу. Үгүй бол хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн

саналаар энэ хурлаа даргалаад явъя. Хурлын дэг, хэлэлцэх асуудлыг ТУЗ-өөс тогтоож өгөөд хувьцаат компанийн үйл ажиллагааг зохицуулдаг холбогдох хуулийнх нь дагуу бид санал болгоод та бүхэнд 3 сард зарлаад, танилцуулж ирсэн. Хурлын хэлэлцэх асуудлыг хурал зохион байгуулж байгаа хүмүүс хувьцаа эзэмшигчдэд тарааж өгсөн байгаа. Бид хурлаа зарлаад хуулинд заасан хангалттай хугацааг өгөөд, хувьцаа эзэмшигчдэд танилцах боломжийг олгож байсан. Манай ТУЗ болон зарим гишүүд маань өнөөдрийн танилцах асуудлуудтай холбоотой материалуудад саналуудаа нэгтгээд бие биендээ өгөөд нээлттэйгээр ажилласан гэдгийг танилцуулья.

Хурлын дарга Ч.Ганхуяг хурлын хэлэлцэх асуудал болон хурлын дэгийг танилцуулж, энэ тухай санал, хүсэлт байхгүй гэснээр хурлын дэгийг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталлаа. ТУЗ-ийн гишүүд болон тооллогын комиссын дарга, гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд танилцууллаа.

Танилцуулга: Хурлын дэгийн дагуу “Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан компанийн 2015 оны үйл ажиллагааны товч тайланг танилцууллаа.

Тайлантай холбоотой асуулт, хариулт:

Хувьцаа эзэмшигч Энхтуяа: Батсайхан захирлаас асуух асуулт байна. Баярлалаа. Сайхан илтгэл болсон байна. Шинэ үйлчилгээнд ачаа тээврийн асуудал нэмэгдэж орж байгаа юм байна. Үүн дээр машины асуудал ямар машин явж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан: Шинэчлэлийн Засгын газар бидний оруулсан төслийг дэмжээд “Монгол хьюндай” ХК-ийн Солонгос улсын HD120, 720 зэрэг 8-20 тн даацтай шинэ машинууд авсан. Эдгээр нь манай ачаа тээврийн үйлчилгээнд явж байгаа. 750 сая төгрөгөөр худалдаж авсан. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд нийт хүргэлтээсээ тэрбум орчим төгрөгийн орлого оруулсан байгаа.

Хувьцаа эзэмшигч Цэрэнпил: “Монгол шуудан” ХК-ийн анхны хувьцаа арилжаалагдахад хувьцаа авсан хүмүүсийн нэг байна. Хувьцаа эзэмшигчдийн анхны ээлжит хурлыг зохион байгуулж байгаа ТУЗ, “Монгол шуудан” ХК-ийн удирдлагуудад талархал илэрхийлье. 2015 оны борлуулалтын орлого 2014 оныхоос бараг 3.1 дахин багассан байна. Энэ нь үйл ажиллагаа маань тодорхой хэмжээнд доголдож байгаагийн илэрхийлэл байх гэж бодож байна. Миний хувьд эдийн засагч хүн биш. Тэгэхдээ хэдэн тоо хараад ойлгох хэмжээний гэж бодож байна. Хувьцаа эзэмшигчид гэдэг чинь төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс байгаа. Та бүхэнд туслах, мэргэжлийн хүмүүс байгаа шүү. Энэ боломжоо ашиглаарай гэдгийг юуны өмнө хэлье. Та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан: 2015 оны 4 сард гүйцэтгэх захирлыг өөрчилж, 2015 онд шинээр хийхээр төлөвлөсөн ажлууд маань хугацаандаа эхэлж чадаагүйгээс орлогын бүрдүүлэлт буурсан. Мөн Улс орны эдийн засгийн байдал бас нөлөөлсөн.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Дөнгөж сая мэдээ ирж байна. Олон нийтэд түгж байгаа мэдээлэл юу вэ гэхээр 7.8 хувийг блок арилжаагаар манай “Хишиг арвин” гэдэг компани авсан шүү гэдэг мэдээллийг брокер диллерийн компаниуд маань тарааж байна. Доод ханш нь 250, дээд ханш нь 308 төгрөгөөр өгөлцөж авсан блок арилжаа Хөрөнгийн бирж дээр явагдсан байна. Энэ бол бодитой зах зээл, бидний хувьцааг авах мөнгө байна. Зүгээр 200-н хувьцааг хүмүүс бие биендээ өгөөд аваад байдаг биш, 2.2 турбум төгрөгөөр танай компанийн 7.8 хувийг хүмүүс өгөлцөж, авалцаж байна гэдэг чинь цаана нь хөрвөх чадвар байна, сонирхол байна, энэ ажиллаж байгаа баг бүрэлдэхүүнд өгч байгаа итгэл байна гэсэн үг юм.

Хэлэлцэх асуудал-1: Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ, ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлт, компанийн болон ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг тус тус батлуулах;

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Та бүхнийг ээлжит хуралдаа идэвхитэй оролцож байгаад талархал илэрхийлье. Хэлэлцэх асуудлын дагуу ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулья. Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу ТУЗ өнгөрсөн жилийнхээ ажлаа дүгнэдэг. Энд үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт яригдана. ТУЗ-ийн Аудитын хорооны тайлан та бүхний танилцаж байгаа материал дотор бүрэн эхээрээ орсон байгаа. ТУЗ-ийн зүгээс Компанийн тухай хуулинд нийцүүлээд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах 2015 оны компанийн үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнд өгөх дүгнэлтийг батлах Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулна. Бусад хувьцаат компанийн хувьд Гүйцэтгэх захирал нь тайлан тавилгүй ТУЗ нь тайлагнаж явдаг. Энэ жил ТУЗ-ийн хурал дээр хэлэлцээд компанийн Гүйцэтгэх захирлаар компанийн үйл ажиллагааг тайлагнуулья гэсэн шийдвэр гаргасан.

Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хорооны дүгнэлт, компанийн болон ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг дэлгэц дээр танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: “Монгол шуудан” ХК нь шуудангийн шинэ дэвшилтэт технологи ашиглаж, шинэ нэр төрлийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлж, олон улсад үр дүнтэй сайн ажиллаж байгаа гэсэн үнэлгээ аваад явж байгаа тул компанийн үйл ажиллагаанд болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн зүгээс “Хангалттай” гэсэн дүгнэлтийг өглөө.

“Монгол шуудан” ХК нь 2015 онд 94 сая төгрөгийн ашигтай ажилласан тул 18,8 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилж, улсын төсөвт төвлөрүүлэх тухай ТУЗ-ийн тогтоолыг баталсан болно.

ТУЗ-ийн шийдвэрээр өгсөн “хангалттай” гэсэн үнэлгээг Та бүхэн хүлээн авч баталж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Асуулт, хариулт:

Хувьцаа эзэмшигч Өлзийбат: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нэг нь байна. Төрийн оролцоо маань 60

гаруй бараг 70 шахуу хувь байна. Миний өөрийн үзэж байгаагаар бизнесийг хийхэд цаг хугацаатай уралдах, цаг хугацаатай уралдахын эцсийн зарчим нь юу вэ гэхээр чиг байгаа байх. Хамгийн хурдан шийдвэр гаргах байдаг гэж би үзэж байна. Тэгэхээр ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчид маань энд байна. Тэр хүмүүс маань төрийн оролцоо буюу төрийн эзэмшиж байгаа хувь ямаршуухан түвшинд байна гэж үзэж байна вэ? Энийг бууруулж болох уу? Эсвэл энэ чигээрээ яваад байх уу? Дараагийн асуудал нь электрон худалдааны талаар цухас дурдаад өнгөрлөө. Би Монгол шууданд хөрөнгө оруулахдаа юуг харж оруулсан бэ гэхээр интернет худалдаа Монгол улсад хөгжих юм байна. Интернет худалдааны авах, зарах нь интернетээр хийгдчихнэ. Тухайн хүндээ бодит байдлаар хүргэгдэнэ. Энэ зах зээл рүү Монгол шуудан маш түлхүү хүч хаяж ажиллах юм байна гэдэг ойлголттой байсан. Гэтэл энэ маань тайланд зүгээр д дурдагдаад өнгөрлөө. Энэ хэр ажил болж явж байна вэ? гэж асуумаар байна. Энэ тал дээр нилээд хүч тавьж ажиллаасаа гэж хүсч байна. Яагаад гэвэл Монгол шуудан компани түрүүн монополь гэж хэлэх шиг боллоо. Би бол тэгэж үзэхгүй байгаа. Монгол улсад өрсөлдөх зөндөө олон шуудангийн компаниуд байгаа. Иймээс олон улсын түвшинд өрсөлдөхүйц компани болж ирэх байх гэж би итгэж байгаа. Сайн ажиллаарай. Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдын хурал Монгол шуудан компанид өгч байгаа мессежүүд маань нилээн Хувьцаа эзэмшигчдийн итгэлийг төрүүлэхүйц ирээдүйд амжилтанд хүрч чадах юм байна гэдэг итгэлийг төрүүлж байгаад маш их баяртай байгаа шүү.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Эхний асуултанд хариулья. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьцааг худалдах, хувьчлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаас баталдаг. Улсын Их хурлаас 34 хувийг хувьчилъя гэсэн шийдвэр гарсан учраас энэ хувиар хувьчилсан. Цаашдаа 66 хувиас нэмж хувьчлах асуудал Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Улсын Их Хурал хувьчлах үндсэн чиглэлээ баталсны дараа Засгийн газар уг шийдвэрийг хэрэгжүүлдэг. Засгийн газар хувьчлахдаа нээлттэйгээр Хөрөнгийн биржээр арилжаалах уу, эсвэл хуульд заасан өөр бусад хэлбэрээр хувь оролцоог багасгах уу гэдгийг шийдвэрлэдэг. Одоогийн байдлаар 66 хувиас нэмж хувьчлах шийдвэр гараагүй байгаа. Интернет худалдааны талаар Батсайхан захирал танилуулбал илүү ойлгомжтой байх.

Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан: “Монгол шуудан” ХК-ийн 2016 оны гол стратегийн бодлого бол энэ асуудал. 2015 оны 9 сараас хойш нийт 7 удаа айлчлал, хэлцэл, гэрээг ОХУ, БНХАУ-ын хооронд интернет худалдааны бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэхээр хийгээд, эхлээд явж байгаа. Сая 2015 оны тайлан ярьсан учраас энэ талаар дэлгэрэнгүй тусгагдаагүй. 2016 онд манай компанийн номер нэгт тавьж байгаа асуудал бол энэ интернет худалдаа юм. Энэ оны сүүлээр нилээд амжилттай тоо баримт та бүхэнд хэлэх байхаа гэж бодож байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Өөр асуух зүйл байна уу. Үгүй бол саяын асуудал дээр нэмж хэлэхэд интернет худалдааны орчныг бүрдүүлэхэд Монголд хэд хэдэн зүйл үгүйлэгдэж байгаа. Энэ нь юу вэ гэхээр хаягжилтын систем. Мөн төлбөрийн хэрэгсэл. Хэдий бид хоорондоо интернет орчинд, утсаар тодорхой хэмжээнд

хоорондоо мөнгө шилжүүлж болж байгаа ч гэсэн үндсэн төлбөрийн хэрэгсэл болох Pay Pal гэх мэт систем Монголд орж ирээгүй байсан. Энийг би хувиараа Ард Санхүүгийн Нэгтгэлийн хувьд тодорхой хэмжээнд шийдвэрлэх гээд, мөн хаягжилтын асуудлыг тодорхой хэмжээнд шийдвэрлэх гээд манай удирдах зөвлөл ажиллаж байна. Дараагийн бизнес төлөвлөгөө төсөлдөө энэ асуудлыг оруулж хийх ёстой ажлын нэг гэж үзэж байна. Улсын Их Хурлаас чиглэл гардаг гэж байгаа. Их хурлын сонгууль удахгүй болно. Тэгэхээр Их хурлыг та бүхэн манай хувьцаа эзэмшигчид сонгоно. Аль болох хувьцаанд олон хүн орох байсан боловч 350 хүн орсон. Гэхдээ Ард Санхүүгийн Нэгтгэл гээд үүний цаана 700 гэр бүл байгаа шүү. Нэг хэсэг хүмүүсийн нийлсэн нэгтгэл биш, маш олон иргэд орж ирээд шуудангийн хувьцааг эзэмшиж байгаа гэдгийг бас дурьдах нь зөв зүйтэй болов уу.

Асуулт, хариулт:

Хувьцаа эзэмшигч Ганболд: ТУЗ-ийн ногдол ашигтай холбоотой зүйл дээр асуух асуулт байна. Компанийн дүрмийн 4.2 дээр байна. “Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол Төлөөлөн удирдах зөвлөлийн энэ тухай шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.” гэж байна. Энд зөвхөн төрийн төлөөлөл дээр 66 хувь ногдол ашиг өгнө гэсэн байна. Шийдвэрт нь дүрмийнхээ заалтаар нэрсийн жагсаалт нь байх ёстой ороогүй байна. Энэ ямар учиртай юм бол. Миний мэдэж байгаагаар өнгөрсөн 25 жилийн хугацаанд ногдол ашиг тарааж байгаа компаниуд Хувьцаа эзэмшигчдийн хуралд суух бүртгэлийн өдрөөр тогтоодог. Өөрөөр хэлбэл энэ хуралд суух жагсаалт гарсан 3 сарын 18-ны өдрөөр хувьцаа эзэмшигчид ногдол авах эрхтэй байдаг. Ингэж явж ирсэн. Монгол шуудан бол төрийн хувьчлалын анхны жишээ. Цаашдаа бусад зүйлд нөлөөлөх вий дээ. Үүнд нэг тайлбар өгөөч.

ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа: ТУЗ-ийн гишүүний болон энэ шийдвэрийг гаргалцсаны хувьд хууль зүйн үндэслэлээс нь тайлбар өгье. Ногдол ашгийн хувьд 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны ашгаас олгож байгаа. 2015 онд 100 хувь төрийн өмч байсан. Төр өөрийн компаниудаасаа ногдол ашиг авч төсөвт төвлөрүүлнэ гэдэг нь Улсын төсвийн тухай хуулиар хүлээсэн үүрэг байдаг. Өмнөх оныхоо санхүүгийн баланс нь гарсаны дараа төр ногдол ашиг авдаг байгаа. Тэгэхээр 2015 оны Санхүүгийн үйл ажиллагааны ашгаас 100 хувь төрийн өмч байсан учраас төр ногдол ашиг авах юм гэж үзэж байна. Компанийн тухай хуулийн 46.12, 46.13 дахь заалтын дагуу 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанаас олсон ашигаа санхүүгийн жил дууссаны дараа санхүүгийн баланс гарсаны дараа авдаг. Өнгөрсөн 3 сард энэ сар дуусаж байгаа учраас анхны шаардлагаар ногдол ашгийг нь өгөх хуулиар хүлээсэн үүрэгтэй. Мөн 46.16 дээр “Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ” гэсэн ийм хуулийн зохицуулалттай юм. Иймд хууль зөрчсөн шийдвэр гаргаагүй ээ гэж үзэж байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Энэ асуудлаар ТУЗ дээр санал явсан. Үүн дээр би наад саналыг чинь хэлсэн. Яагаад вэ гэхээр бид хувьцаат компани. ТУЗ ногдол ашгийн хувийг гаргах бүрэн эрхтэй. Яг энэ асуудал дээр бид санал нэгдэж чадаагүй. Бид уужуу тайван ухаанаар ойлгож чадвал 18 сая төгрөгний тухай ярьж байгаа. Бид авсан аваагүй материаллаг өөрчлөлт оруулахгүй зүйлийн тухай ярьж байгаа учраас энэ асуудлыг хаавал яасан юм бэ? Дэгийнхээ дагуу завсарлах уу, эсвэл шууд дүрмийн өөрчлөлтийн асуудлаа ярилцах уу?

Хуралд оролцогчдын саналаар завсарлага авахгүйгээр хурлаа цааш үргэлжлүүлэхээр шийдвэрлэлээ.

Хэлэлцэх асуудал-2: Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг танилцуулах, шийдвэрийн төсөл хэлэлцэх;

Хурлын дарга Ч.Ганхуяг: Дэлгэрмаа гишүүн Дүрмийн өөрчлөлтийг танилцуулна. Бодит байдал юу байна гэхээр манай Сангийн яамны нөхдүүд маань удирдамжтай хүрээд ирсэн байгаа. Би энэ байдлыг өөрчлөхийн төлөө явна. Нээлттэй хэлээд байгаа. Гэхдээ 66 хувиар асуудал бол шийдэгдээд явчихна.

ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа: Дүрмийн төсөл дээр ТУЗ 2 удаа хуралдаж эцсийн байдлаар санал хурааж олонхийн саналаар энд танилцуулах гэж байгаа дүрмийн төслийг дэмжсэн байгаа.

ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл болон гол гол өөрчлөлтүүдийг дэлгэрэнгүйгээр танилцууллаа.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Гол өөрчлөлтүүдтэй холбоотой асуулт байна уу? Манай ТУЗ маш шаргуу ажилласан. Удирдах зөвлөл дээрээ санал нэгдсэн байгаа. 75 хувиар бүрдүүлэх нь өөрөө төр ганцаараа хүрч ирээд өөртэйгөө хурлаа хийгээд дангаараа шийдвэр гаргаад явчихгүй ээ гэдэг тийм зүйлийг зах зээл дээр дохио өгье. Сангийн яамнаас өнөөдрийн хуралд удирдамж ирсэн байгаа. Удирдамжийн дагуу ТУЗ-өөс гаргасан шийдвэр гол зарчмын өөрчлөлтийг дэмжих боломжгүй гэсэн удирдамж ирсэн юм байна. Тэр бол харамсалтай үйл явдал гэж би хувьдаа бодож байна. Асуулт, санал байна уу?

Хувьцаа эзэмшигч Цэрэнпил: Санхүүгийн зохицуулах хорооноос нээлттэй компаниудад тавьдаг зарчим байдаг. Тэрэнд нийцэж байгаа юу?

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Би төрийн өмч буюу Монгол шуудан ХК-ийн 66 хувийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж ирсэн. Хувьцаа эзэмшигчийг төлөөлж ирж байгаа төлөөлөгч хувьцаа эзэмшигчээсээ чиглэл, удирдамжтай ирдэгийн нэгэн адил Сангийн яамнаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу удирдамж өгдөг. Энэ бол би өөрийнхөө хувийн эрх ашгийг төлөөлж энд сууж байгаа биш. Төрийг төлөөлж байгаа. Компанийн дүрмийг батлах тухай хэлэлцэх асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түтгэлзсэн гэсэн 3 үзүүлэлттэй саналын хуудас бидэнд өгсөн байгаа. Би дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахдаа шууд зөвшөөрсөн гэдэг дээр тавихгүй. 2 заалтыг хассанаар зөвшөөрье гэсэн томъёоллоор санал хураалгамаар байна. Компанийн дүрмийн 6

дугаар зүйлийн 6.13, 6.14 дүгээр заалтыг хасуулах саналтай байна. Өөрийнхөө тавьж байгаа саналын үндэслэлийг тайлбарлая. **1-рт:** Дүрмийн төслийн 6.13 дахь заалтад “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэсэн заалтыг 66 хувийн хувьцаа эзэмшигч хасуулах санал тавьж байна. Үндэслэлийг тайлбарлахын тулд Компанийн тухай хуулийн 69.1-ийг уншиж танилцуулья. “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно”. 66 хувь ганцаараа хуралдчихна гэдэг асуудлаас илүү Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөж байгаа Компанийн тухай хуулийн заалтыг өөрчлөхгүйгээр хуулиараа явъя гэж байгаа юм.

2-рт Дүрмийн төслийн 6.14 дэх заалтыг бас хасах санал тавьж байна. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн 75-аас дээш хувийн саналаар хүчин төгөлдөр болно” гэж байгаа. Энэ заалт маань Компанийн тухай хуулийн 63.5 дээр тул хуулийн заалтаар нь зохицуулж байхаар үлдээе гэсэн үг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох хувийг заавал 75 хувь болгож өсгөх шаардлагагүй гэж үзэж байна. Компанийн тухай хуулийн 63.5 дээр “Энэ хууль болон компанийн дүрэмд зааснаас дээгүүр хувь тогтоогоогүй, эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно” гэсэн байна.

ТУЗ-ийн гишүүн Ж.Оюунгэрэл: Бид ТУЗ-ийн хурлаар хэлэлцээд, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс бүгдээрээ шийдсэн зүйлийг СЯ ингэж өөрчлөөд байвал бидний ТУЗ ч гэж байх хэрэг алга. Санал хураалтанд би лав оролцохгүй. Хэвлэлийн бага хурал хийнэ.

Санал хураалтанд оролцохгүй гэснээр ТУЗ-ийн гишүүн Ж.Оюунгэрэл хувьцаа эзэмшигчдийн хурлыг орхин гарлаа.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Сангийн яам бол 66 хувьтай. ТУЗ дээр бидний оруулсан саналаар бол ядахдаа нэмээд 9 хувь жижиг хувьцаа эзэмшигчидын төлөөлөл оролцож байж энэ хурал хүчин төгөлдөр байх. Тэр 75 хувиа цугларчихаар мэдээж Сангийн яам олонхоороо шийдвэрээ гаргачихна. Энэ асуудал маань бидний хувьд эргэлзээ төрүүлчихлээ.

Хувьцаа эзэмшигч Энхтуяа: Компанийн шиечилсэн дүрмийн найруулгыг ТУЗ-ийн хурлаар шийдвэр гараад ирчихсэн юм чинь дахиад энд санал аваад, хасаад байх шаардлага байгаа юм уу. Хувийн байгууллага, төрийн өмч 2-ийн хооронд зөрчил үүсэх гээд байгаа юм биш үү. 75 хувь байхад юу зөрчигдөөд байгаа юм бэ? Тайлбарлаж өгөөч. Тэгэж оруулахгүй л байсан юм бол яах гэж энд бичсэн юм бэ?

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Би тайлбар хэлье. Хуулиас давсан юм хийгээгүй ээ. Төр гэдгээр нь 66 хувийн хувьцаа эзэмшигчийг буруутгаад байгаатай санал нэгдэхгүй байна. Тийм учраас төрийн 100 хувийн компаниуд ч, хувийн 100 хувийн компаниуд ч, тэдгээрийн холимог оролцоотой компаниуд ч гэсэн хувьцаа

эзэмшигчдын хурлаа яг энэ хууль болон дүрмийнхээ дагуу явуулж байгаа. Төр хуулиас гадуур юм хийгээд байгаа юм байхгүй. Мөн энэ хурлаар дүрмийн төсөл танилцуулж батлуулахаар оруулж ирсэн болохоос баталсан дүрэм яриагүй. Одоо бид энэ дүрмээ батлана. Би 66 хувийг төлөөлж саналаа хэллээ, бусад хувьцаа эзэмшигчид саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч Х.Батхишигийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Тулгат: Юуны өмнө Компанийн дүрмийн өөрчлөлтийн төсөл дээр шаргуу ажиллаж нилээд бололцооны дүрэм гарсан болов уу гэж би бодож байна. Ажилласан багтаа баярлалаа гэж хэлье. Гарч байгаа асуудал дээр өөрийн байр сууриа илэрхийлье. Миний бодлоор бол энэ 2 заалтыг хасвал зөв болов уу? Төр юу юугүй шууд хүч түрээд, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироогоод явахгүй байх. Өнөөдрийн нөхцөл байдал дээр хэвлэл мэдээлэл, олон нийт бусад бүх сувгаар байнгын олон нийтийн хяналт явагдах бүрэн боломжтой. Үнэхээр асуудал гарч ирсэн тохиолдолд бид эрх зүйн зохицуулалт хийлгээд энэн дээр өөрсдөө өөрчлөлтөө шат дараатай оруулаад явах боломжтой болов уу гэж би бодож байна. Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Компанийн тухай хуулиараа бол 6.13, 6.14-д байгаа заалтууд бол хуулиас давсан заалт болж байна гэж би харж байна. Энэ 2 заалт асуудалтай заалт байна, энэ заалтыг хасах нь зөв юм болов уу гэсэн бодолтой байна. Хэтэрхий яарч хуулиас давсан зүйл хийгээд байх нь зохимжгүй юм болов уу. 2-рт Манай хувьцаа эзэмшигчийн хувьд хувьцааны хувь 13 боллоо. Бид “Монгол шуудан” ХК-ийнхаа үйл ажиллагаанд маш их хүч чармайлттай оролцоно гэж бодож, шуудан харилцааны салбарт томоохон өөрчлөлтүүдийг хийе гэж нэмж хувьцаа худалдаж авсан. Бид өмнөх хуралдаанаар ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орж чадаагүй. Иймээс ТУЗ-ийн үндсэн гишүүнээр орох хүсэлтэй байгаа. Гэсэн хэдий ч 9 хүнтэй ТУЗ-ийн бүрэлдэхүүн маань аль хэдийн бүрдээд батлагдсан байгаа. Миний оруулах гэж байгаа санал бол Компанийн дүрмийн 7.2 дээр ТУЗ нь 9 гишүүнтэй байна гэсэн заалтыг 13 гишүүнтэй байх саналыг оруулж байна. Үүний үндэслэл нь юу вэ гэхээр ТУЗ дэх хороо маань нэмэгдээд 4 хороотой болох гэж байгаа юм байна. “Монгол шуудан” ХК-ийг цаашид улам сайн хөгжүүлэхэд ТУЗ-ийн бүрэлдэхүүн нилээд хүчтэй сайн багийг бий болгож 4 хороо дээр ТУЗ-ийн гишүүд гурав гурваараа ажиллвал илүү оролцоотой болох боломжийг бүрдүүлбэл ямар байдаг юм болоо. Ийм бодол байна. Ийм саналыг хурлаар оруулж байна. Хувьцаа эзэмшигч та бүхэн үүнийг шийдэж өгнө үү.

Хурлын дарга Ч.Ганхуяг: За баярлалаа. Би 2 зүйлийг хэлчихье. Бидний хувьд Ард Санхүүгийн Нэгтгэл ХХК-ийн ард 700 хувьцаа эзэмшигчид байгаа. Бид өөрсдөө хөрөнгийн бирж дээр гарна. Манай энэ дүрмийг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэх ёстой. Харамсалтай нь 66 хувийн төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа Сангийн яамны хүмүүсийн хувьд ТУЗ-өөс гарсан олон нийтийн, дэлхий нийтийн жишгийг үл тоохоор шийдсэн байна. Энэ заалтанд хуулиас давсан зүйл байхгүй. Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг битгий орхигдуулаач ээ гэсэн заалтыг л оруулж байгаа юм. Төр ганцаараа сууж байгаад өнөөдөр 66 хувь бүрдчихлээ. Ирц бүрдчихлээ гээд харанхуйд жижиг хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хөсөрдүүлээд хурал хийх боломж байхгүй юм шүү гэдгийг бид зах зээл

дээр дохио болгох үүднээс тэр заалтыг оруулсан. Ядахдаа 75 хувь байна. Энэ зорилгоосоо бид няцахгүй ээ. Манай ТУЗ-ийн дарга сая нилээн бухимдлаа. Энэ асуудлаар олон түмэндээ хандана гэсэн байгаа. Тэр саяын тавьсан зөв жишгийг мөрдөхийн төлөө ажиллана. Энэ зарчмаасаа бид ухрахгүй ээ. Одоо яаж шийдэх үү гэдгийг би мэдэхгүй байна. Би та бүхнээсээ, хувьцаа эзэмшигчдээс хүлцэл өчөөд, манай ТУЗ-ийн дарга маань энэ хурал дээр байх боломжгүй гэж үзсэн. Иймээс би гүйцэтгэх албыг нь хариуцаж байгаа хүний хувьд цааш үргэлжлүүлж, оролцож, энэ хурлыг даргалах боломжгүй болчихож байна. Тэгэхээр завсарлахаас өмнө гарах болж байна. Уучлаарай.

Цаашид хурлыг даргалаад явах боломжгүй гэснээр Хурлын дарга буюу Монгол шуудан ХК-ийн 17,38 хувийн хувьцаа эзэмшигчийг төлөөлөн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон Ард санхүүгийн нэгдэл ХХК-ийн захирал Ч.Ганхуяг хурлыг орхин гарлаа.

Хурлын дэгийн дагуу цайны завсарлага хийж 30 минутын хугацаатайгаар хурал түр завсарлалаа.

Хурал 12:50 минутад дахин үргэлжлэв.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Та бүхэнд санал болгох зүйл байна. Хурлаа үргэлжлүүлэе гэсэн саналтай байна. Үргэлжлүүлээд ирц бүрдэж байгаа тул зааланд байгаа хувьцаа эзэмшигчид дундаас хурал даргалагчийг сонгоё. Хурал даргалагч хийх саналтай хувьцаа эзэмшигч байна уу?

Хувьцаа эзэмшигчдээс хурлаа үргэлжлүүлэх эсэх талаар санал хураалт авснаар хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 80,37 хувийн (хурал үргэлжлүүлж буй хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн) саналаар хурлаа цааш үргэлжлэхээр боллоо.

Хуралд оролцож байгаа Хувьцаа эзэмшигчдийн саналаар ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэлээр хурлыг даргалуулахаар болж, хурлыг цааш үргэлжлүүлэн явууллаа.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Хэлэлцэх асуудлын жагсаалтын дараагийн дугаарт ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын төсвийн асуудал байгаа учраас заалнаас буюу хувьцаа эзэмшигчийн гаргасан саналаар ТУЗ-ийн гишүүнийг тоог нэмэгдүүлэх санал тавьсан учраас бид энэ танилцуулга дээр тэр асуудал дэмжигдэх эсэх асуудлыг шийдсэний дараа төсвийг батлахгүй бол болохгүй нь. Иймээс санал асуулгыг явуулаад дараа нь цалин урамшууллын төсвийг батлах уу гэсэн санал байна.

Хувьцаа эзэмшигч Ганболд: 13 гэсэн саналыг дэмжиж байгаа. Яагаад гэхээр түрүүчийн ТУЗ-ийн гишүүн 9 хүний бүрэлдэхүүнтэй байсан. Энд жижгийн жижиг хувьцаа эзэмшигчдээс ер хүн ороогүй. Энэ хүмүүсээс 13 дотор оруулах ёстой гэж үзэж байна.

Хурал даргалагч Д.Нарангэрэл: Саналыг дэмжих эсэх нь саналын хуудсаар шийдэгдэнэ. Тийм учраас одоо бид эхний хэлэлцсэн асуудалтай холбоотой хэдэн

асуудал дээр гар өргөх байдлаар санал авья гэсэн саналтай байна. “Компанийн 2015 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай” гэсэн ТУЗ-ийн шийдвэрийг гар өргөж баталъя гэсэн санал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын 17-р хуудсанд байгаа “Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай” гэсэн томъёоллоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг тогтоолыг батлах уу? Батлая гэсэн саналтай хүмүүс нь гараа өргөнө үү. (гар өргөж санал хурааснаас гадна энэхүү санал хураалтыг саналын хуудсаар баталгаажуулсан байгаа)

Шийдвэрлэсэн нь: Хэлэлцэх асуудал буюу Компанийн 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хорооны дүгнэлт, компанийн болон ТУЗ-ийн 2015 оны үйл ажиллагааны тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг шууд санал хураалтаар буюу анх хуралд оролцохоор бүртгүүлсэн нийт хувьцаа эзэмшигчдийн 70,951,533 ширхэг хувьцаа буюу 80.38 хувийн саналаар батлав.

Хурал даргалагч Д.Нарангэрэл: Дараагийн асуудал болох Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай ТУЗ-ийн тогтоолын төсөл саналын хуудсаар саналаа өгнө. Зөвшөөрсөн, татгалзсан, түтгэлзсэн гэсэн 3 асуулга бүхий саналыг хуудсаар саналаа өгнө үү.

Дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай ТУЗ-ийн тогтоолын төсөл дээр Хувьцаа эзэмшигчдийн зүгээс гарсан дараахь саналыг харгалзан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахаар боллоо. Үүнд:

1. Компанийн дүрмийн төслийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалтыг хасах;
2. Компанийн дүрмийн төслийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх заалтыг хасах;
3. Компанийн дүрмийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх” гэсэн заалтыг 13 гишүүнтэй байх гэж өөрчлөлт оруулах;

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлаар саналын хуудсаар саналаа өглөө.

Хувьцаа эзэмшигч Ганболд, Энхтуяа нэр дуурх асуудалтай холбоотой өөр өөрсдийн санал бодлоо илэрхийллээ. Энэ дагуу хурлын дарга Д.Нарангэрэл тайлбар өглөө.

Тооллогын комисс саналын хуудсыг нэгтгэж, комиссын дарга Ө.Сугар санал хураалтын нэгдсэн дүнг танилцууллаа.

Санал асуулгад 70,951,533 ширхэг хувьцаатай 7 хувьцаа эзэмшигч оролцлоо.

- “Компанийн дүрмийн төслийн 6 дугаар зүйлийн 6.13 дахь заалтыг хасах” гэсэн санал дээр зөвшөөрсөн 70,948,393 ширхэг хувьцаа буюу 80.38 хувь, татгалзсан 3,140 ширхэг хувьцаа буюу 0,0036 хувь, түтгэлзсэн санал байхгүй.
- “Компанийн дүрмийн төслийн 6 дугаар зүйлийн 6.14 дэх заалтыг хасах” гэсэн санал дээр зөвшөөрсөн 70,948,393 ширхэг хувьцаа буюу 80.38 хувь, татгалзсан 3,040 ширхэг хувьцаа буюу 0.003 хувь, түтгэлзсэн 100 ширхэг хувьцаа буюу 0.0001 хувь.

- “Компанийн дүрмийн төслийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх” гэсэн заалтыг 13 гишүүнтэй байх гэж өөрчлөлт оруулах” гэсэн санал дээр зөвшөөрсөн 70,934,992 хувьцаа буюу 80.37 хувь, татгалзсан 16,541 буюу 0,02 хувь, түдгэлзсэн санал байхгүй.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Компанийн тухай хуулийн 17.1-д “... Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална” гэж заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон нийт гишүүдийн дийлэнх олонхын санал авсан тул Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг уншиж танилцуулья. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Монгол шуудан” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн “Монгол шуудан” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал даалгасугай” гэсэн тогтоол батлагдлаа.

Хэлэлцэх асуудал-3: ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал болон 2016 оны зардлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах;

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дарга Б.Батзаяа ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал болон 2016 оны зардлын төлөвлөгөөний төслийг танилцууллаа.

ТУЗ-ийн гишүүний тоог 13 болгох санал дэмжигдэн Компанийн дүрэм батлагдсан учраас цалингийн зардал дээр нэмэлт өөрчлөлт орсноор Хувьцаа эзэмшигчдийн шууд санал хураалтын дүнгээр ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулал болон 2016 оны зардлын төлөвлөгөөг баталлаа. Саналын зөрүүтэй асуудал байхгүй гэснээр шууд санал хураалтанд 7 хувьцаа эзэмшигч оролцож, оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн санал буюу хуралд бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн 80,38 хувийн саналаар дэмжигдлээ.

Хурлыг хааж хурлын дарга Д.Нарангэрэл: Та бүхнийг хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирж, идэвхитэй оролцсон явдалд баяр хүргэе. Дурсгалын зураг авахуулаад хувьцаа эзэмшигчдийн хурлаа өндөрлөө.

ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдах албан тушаалтнууд болон хувьцаа эзэмшигчид дурсгалын зураг авахууллаа.

Хурал 14:05 цагт өндөрлөлөө.

(Энэхүү хурлын тэмдэглэл нь Тооллогын комиссын дүгнэлт, саналын хуудаснуудын хамт хүчин төгөлдөр болно)

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ